



2020 оны 09 дүгээр сарын 18
№35 /1137/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Хэлэлцээр соёрхон
батлах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Зээлийн хүүг бууруулах
стратегии батлах тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Журам батлах
тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

421. Хэлэлцээр соёрхон батлах тухай 1926

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

422. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 18 1926

423. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 19 1926

424. Зээлийн хүүг бууруулах
стратеги батлах тухай Дугаар 21 1927

425. Сонгуулийн Ерөнхий хорооны дарга,
нарийн бичгийн даргыг томилох тухай Дугаар 26 1938

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

426. Улсын начин цол олгох тухай Дугаар 98 1938

427. Улсын харцага цол олгох тухай Дугаар 99 1939

428. Улсын цол олгох тухай Дугаар 100 1940

429. Улсын заан цол олгох тухай Дугаар 101 1940

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

430. Журам батлах тухай Дугаар 113 1941

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

431. “Хамтран ажиллах тухай Монгол Улсын
Засгийн газар, Уур амьсгалын ногоон
сан хоорондын хэлэлцээр” 1957



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Уур амьсгалын ногоон сан хооронд 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Уур амьсгалын ногоон сан хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Биеийн тамир, спортын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хавсралтаар баталсугай.

2.Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд дараах чиглэлээр хавсралтад заасан арга хэмжээг яаралтай авч, зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын 1 хувьд хүргэхээр хэрэгжилтийг хангаж, хагас жил тутам Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх;

2/зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах;

3/банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах;

4/хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



ЗЭЭЛИЙН ХҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ

Д/д	Чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Дэд арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
1	Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх	1.1. Төсвийн тогтвортой байдал, сахилга батыг хангах, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх 1.2. Экспорт, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, гадаад эх үүсвэрийн өртгийг бууруулах 1.3. Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулж, дотоод эх үүсвэрийн өртгийг бууруулах	1.1.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээг баримтлах	Засгийн газар	2020-2021
			1.1.1. Гадаад валютын орох урсгалыг дэмжиж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх	Засгийн газар	2020-2021
			1.1.3. Олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагчтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх	Засгийн газар, Монголбанк	2020-2021
			1.2.1. Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас бага хүүтэй экспортын санхүүжилт бүрдүүлэх	Засгийн газар, Монголбанк	2020-2024
			1.2.2. Засгийн газрын "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, Монголбанкинд алт тушаалтыг нэмэгдүүлэх	Монголбанк	2020-2021
			1.2.3. Гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг сайжруулах	Монголбанк	2020-2021
			1.2.4. Экспортын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах дэд бүтцийг байгуулах ажлыг хувийн хэвшилд түшиглэн эрчимжүүлэх	Засгийн газар	2020-2024
			1.3.1. Инфляцыг зорилтот түвшин /6 хувь орчим/-д хадгалах	Монголбанк	2020-2024
			1.3.2. Нийлүүлэлтийн инфляцыг бууруулахад чиглэсэн дэд бүтцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх	Засгийн газар	2020-2024

	<p>1.4.1.Уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарын зээлдэгчид бага хүүтэй зээл олгох нөхцөлийг дараах байдлаар бүрдүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Уг салбарт банкнаас олгосон хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах; - Зээлээр баталгаажсан үнэт цаастай холбоотой тусгай зөвшөөрөл олгох, үнэт цаасыг бүртгэх талаар холбогдох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх; - Мөнгөний бодлогын хороогоор мөнгөний бодлогын хэрэгслээр олгох санхүүжилтийн хэмжээ, нөхцөлийг инфляц, ханш болон гадаад валютын нөөцөд үзүүлэх нөлөөллийг харгалзан тухай бүр нь хэлэлцэн шийдвэрлэсний үндсэн дээр баталгаажсан үнэт цаасыг барьцаалсан Төв банкны репо санхүүжилтийг 1-2 жилийн хугацаатай, бодлогын хүүтэй ойролцоо хүүтэй олгож эх үүсвэр бүрдүүлэх. 	<p>Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо</p> <p>2020-2021</p>
	<p>1.4.Экспортын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах</p>	<p>Монголбанк</p> <p>2020-2021</p>
	<p>1.4.2.Эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлын төлөвтэй уялдуулан төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг шат дараатай бууруулж, банкны салбараас олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх</p>	

		<p>1.5.1.Хөрвөх чадвартай хадгаламжийн сертификатыг бий болгох</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк</p>	<p>2020-2021</p>
		<p>1.5.2.Өртгийн сүлжээнд тулгуурласан санхүүжилтийн бүтээгдэхүүн бий болгох</p>	<p>Монголбанк, Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо</p>	<p>2020-2024</p>
	<p>1.5.Санхүүгийн зах зээлд зээл, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>1.5.3.Банк, санхүүгийн салбарт хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах, ач холбогдлыг сурталчлахад дэмжлэг үзүүлэх</p> <p>1.5.4.Жижиг, дунд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, эрэлт, хэрэгцээнд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, хөдөө аж ахуйн салбарын өртгийн сүлжээнд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх</p>	<p>Монголын банкны холбоо Монголын банкны холбоо, Монголбанк Монголын банкны холбоо, Монголбанк, Засгийн газар</p>	<p>2020-2024 2020-2024</p>
		<p>1.5.5.Гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх</p> <p>1.5.6.Банкны зээлийн бүтээгдэхүүнийг боловсронгуй болгож, иргэдийн шууд орлогоор барьцаалсан бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулах</p>	<p>Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо</p>	<p>2020-2024</p>

		<p>1.6.1.Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэрийн хуримтлал гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах чиглэлд макро зохистой бодлогын шинэ хэрэгслийг нэвтрүүлэх</p>	Монголбанк	2020-2024
		<p>1.6.2.Гадаад валютын хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх</p>	Засгийн газар	2020-2024
		<p>1.6.3.Банкны гадаад зах зээлээс татсан гадаад валютын эх үүсвэрийг үндэсний мөнгөн тэмдэгтэд хөрвүүлж, бага хүүтэй зээл олгох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах</p>	Монголбанк	2020-2024
	<p>1.6.Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэр гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах</p>	<p>1.6.4.Гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй байх болон иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээ, төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх талаар Банкнн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх</p>	<p>Монголбанк, Засгийн газар, Хадгаламжийн даатгалын корпораци</p>	2020-2024
		<p>1.6.5.Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн гадаад валютын орлогыг 30 хоногийн дотор Монгол Улсад оруулах, гадаад валютаар гарах зардлаас давсан орлогыг төгрөгт хөрвүүлэх зохицуулалт бий болгох</p>	Засгийн газар	2020-2021



	<p>1.7. Харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй, хүү, түүнтэй төстэй бусад төлбөр төлөхгүй байх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах</p>	<p>1.7.1. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх</p>	<p>Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар</p>	<p>2020-2021</p>
	<p>1.8. Банкны салбарт өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх</p>	<p>1.8.1. Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох</p>	<p>Засгийн газар, Монголбанк</p>	<p>2020-2024</p>
<p>2</p>	<p>2.1. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох</p>	<p>2.1.1. Зээл төлөх хөшүүргийг ашиглаж, чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг эрчимжүүлэх, шүүхийн бус журмаар шийдвэрлэх агуулгаар Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай, Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх</p>	<p>Засгийн газар, Монголбанк</p>	<p>2020-2021</p>
		<p>2.1.2. Үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулах явцад санхүүгийн хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах,</p>		

	<p>хамгаалах агуулгаар Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, эзэлийн үйл ажиллагааны тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх</p> <p>2.1.3. Санхүүгийн хэрэгслийг ангилах, хэмжих, түүний үнэ цэний бууралтыг тооцох тухай Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартыг банкуудад мөрдүүлэх</p> <p>2.1.4. Банкны тогтворжуулалтын сангийн бүрдүүлэлт, түүний зарцуулалт, хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах журам, банкаас банкныг тогтворжуулах болон Монголбанкнаас банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх журмыг олон улсын сайн туршлагад үндэслэн боловсруулж, банкны өр барагдуулах тогтолцоог боловсронгуй болгох</p> <p>2.2.1. Банкны зохистой засаглалын журмыг олон улсын жишгт нийцүүлж өөрчлөх</p> <p>2.2.2. Банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, банк хувьцаат компанийн хэлбэртэй байх агуулгаар Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах</p> <p>2.2.3. Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, ашигт ажиллагааны зорилт, гүйцэтгэх удирдлагын цалин,</p>	<p>Засгийн газар, Монголбанк</p> <p>Засгийн газар, Монголбанк</p> <p>Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо</p>	<p>2020-2021</p> <p>2020-2024</p> <p>2020-2024</p>
	<p>2.2. Банкны засаглал, хяналтыг сайжруулах</p>	<p>Монголбанк</p> <p>Монголбанк</p>	<p>2020-2021</p> <p>2020-2024</p>



		урамууллыг тухайн санхүүгийн жил, үйл ажиллагаа, ашигт ажиллагаагаар бус урт хугацааны үзүүлэлт, үр дүнгээр тогтоодог байх агуулгаар холбогдох журам гаргаж, хэрэгжүүлэх	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2024
	2.3.Банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх	2.3.1.Зээлийн нийлүүлэлтийн тасалдлаас сэргийлж банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилгоор банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх	Монголбанк, Засгийн газар	2020-2021
		2.4.1.Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2021
	2.4.Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх	2.4.2.Банкны санал болгож байгаа зээлийн хугацаа, хүү, шимтгэл, хураамжийг зээлийн төрөл бүрээр харьцуулсан мэдээллийг олон нийтэд тогтмол гаргаж, банкны харилцагч, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Монголын банкны холбоо, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2021
		2.4.3.Барьцаалан зээлдүүлэх газар, иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгож, мөнгө хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох	Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо	2020-2024
		2.4.4.Мөнгө хүүлэлтийг хязгаарлах зорилгоор зээлийн хүүгийн хязгаарыг тогтоох /Банк, банк бус буюу тусгай зөвшөөрлөөр зээллэг тогтодог байгууллагуудын хүү/		

		<p>2.5.1.Зээлийн мэдээллийн санд бүх төрлийн санхүүгийн байгууллагын зээлтэй холбоотой мэдээллийн агуулгыг өргөжүүлж, олон улсын жишигт нийцсэн программ хангамжийг ашиглах</p> <p>2.5.2.Зээлийн мэдээллийн сан болон төрийн эрх бүхий байгууллагын мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох боломжийг бий болгож, мэдээллийн сангийн найдвартай байдлыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэх</p> <p>2.5.3.Банкны зээлийн эрсдэлийн судалгааг сайжруулж, зээлдэгчийн зээлийн эрсдэлийн үнэлгээг хийх бие даасан институцийг хувийн хэвшилд суурилан байгуулах</p>	<p>Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо</p> <p>Монголбанк, Засгийн газар</p> <p>Засгийн газар, Монголбанк</p> <p>Монголбанк, Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо</p> <p>Монголбанк, 2020-2021</p> <p>2020-2021</p> <p>2020-2024</p> <p>2020-2024</p>	
	<p>2.5.Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэх нөхцөлийг бүрдүүлэх</p>			
<p>3</p>	<p>Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах</p>	<p>3.1.Банк, санхүүгийн салбарт санхүүгийн технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх</p>	<p>3.1.1.Технологийн дэвшлийг санхүүгийн салбарын үйлчилгээнд ашиглах ажлыг эрчимжүүлэх</p>	<p>3.1.2.Зээлийн, барьцааны, даатгалын зэрэг гэрээ, хэлцлийг цахимаар хийж, баталгаажуулах агуулгаар Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх</p>



		<p>3.1.3.Төлбөрийн карт уншигч, бэлэн мөнгөний автомат машины нэгдсэн стандарт тогтоож, үйл ажиллагааны зардлыг бууруулах</p>	<p>Монголбанк, Монголын банкны холбоо</p>	2020-2021
	<p>3.2.Банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг багасгах</p>	<p>3.2.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Зээлийн мэдээллийн тухай, Өрсөлдөөний тухай, Татварын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх</p>	<p>Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо</p>	2020-2021
	<p>4.1.Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж, дэмжих</p>	<p>4.1.1.Холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх</p>	<p>Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо</p>	2020-2021
<p>4</p>	<p>Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах</p>	<p>4.2.Компанийн өрийн хэрэгсэл гаргах зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулж, биржийн бус зах зээлийг хөгжүүлэх</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо</p>	2020-2024
	<p>4.3.Үндэсний хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг тэтгэврийн сан, үндэсний хуримтлалын сан зэрэг</p>	<p>4.3.1.Сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулах агуулгаар сангийн эрх зүйн байдал, харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх</p>	<p>Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо</p>	2020-2024

			<p>нийтийн өмчлөл бүхий сангаас хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлдэг байх эрх зүйн орчныг бий болгох</p>	
2020-2024	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	4.4.1.Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах санал болговсруулж, уламжлах	<p>4.4.Банк хөрөнгийн зах зээлд оролцох зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зээлийн бус хэлбэрээр санхүүжилт олгох нөхцөл бүрдүүлэх</p>	

---00---



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, нэгдсэн хуралдааны санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Пүрвээгийн Дэлгэрнарэнг, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргаар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Даваанямын Даваа-Очирыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 07 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар
хот

Улсын начин цол олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн улсын баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд 5 давсан дараах бөхчүүдэд “Улсын начин” цол олгосугай.

- | | |
|-----------------------------|--|
| 1. Төрмөнхийн
Дүгэрдорж | Завхан аймгийн Отгон сумын харьяат, “Сүлд” спорт хороо, “Даян” дэвжээний бөх |
| 2. Доржхандын
Хүдэрбулга | Төв аймгийн Өндөрширээт сумын харьяат, “Сүлд” спорт хороо, “Дүнжингарав” дэвжээний бөх |



- | | |
|--------------------------------|--|
| 3. Шархүүгийн
Пүрэвгарьд | Завхан аймгийн Баянтэс сумын харьяат, “Алдар” спорт хороо, “Даян” дэвжээний бөх |
| 4. Хутагийн
Цогтгэрэл | Булган аймгийн Хутаг-Өндөр сумын харьяат, “Алдар” спорт хороо, “Булган хангай” дэвжээний бөх |
| 5. Цэдэндоржийн
Мөнхбаяр | Увс аймгийн Тэс сумын харьяат, “Сүлд” спорт хороо, “Увс нуур” дэвжээний бөх |
| 6. Нурланы
Мустафа | Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын харьяат, “Өлгийн хүчтэн” дэвжээний бөх |
| 7. Оюунбаатарын
Мөнх-Эрдэнэ | Архангай аймгийн Хайрхан сумын харьяат, “Алдар” спорт хороо, “Бөх билэгт” дэвжээний бөх |

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 07 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 99

Улаанбаатар
хот

Улсын харцага цол олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн улсын баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд 6 давсан дараах бөхчүүдэд “Улсын харцага” цол олгосугай.

- | | |
|------------------------------|--|
| 1. Цэдэнбазарын
Одбаяр | Өмнөговь аймгийн Ханхонгор сумын харьяат, “Алдар” спорт хороо, “Говийн хүчтэн” дэвжээний бөх |
| 2. Батсуурийн
Бат-Орших | Баянхонгор аймгийн Богд сумын харьяат, “Хилчин” спорт хороо, “Хонгор нутаг” дэвжээний бөх |
| 3. Батсүхийн
Зоригтбаатар | Архангай аймгийн Батцэнгэл сумын харьяат, “Алдар” спорт хороо, “Бөх билэгт” дэвжээний бөх |

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 07 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 100

Улаанбаатар
хот

Улсын цол олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн улсын баяр наадмын Үндэсний сурын харваанд эрэгтэй харваачдаас 40 сумнаас 38 сум онож түрүүлсэн Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын уугуул, Монгол Улсын мэргэн Дамиранбазарын Дэмбэрэлсайханд Монгол Улсын “Даян мэргэн” цол, 36 сум онож, 2 дугаар байр эзэлсэн Баян-Өлгий аймгийн Булган сумын уугуул, Монгол Улсын спортын мастер, Аймгийн мэргэн Дүгэржавын Баттулгад Монгол Улсын “Гарамгай харваач” цол, 36 сум онож, 3 дугаар байр эзэлсэн Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын уугуул Монгол Улсын спортын мастер, Аймгийн мэргэн Пүрэвийн Явуухуланд Монгол Улсын “Гоц харваач” цол, эмэгтэй харваачдаас 40 сумнаас 36 сум онож түрүүлсэн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын уугуул, Монгол Улсын спортын мастер Лхагвасүрэнгийн Одсайханд Монгол Улсын “Мэргэн” цол тус тус олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 07 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 101

Улаанбаатар
хот

Улсын заан цол олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн улсын баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд 7 давсан Архангай аймгийн Цэнхэр сумын харьяат, “Алдар” спорт хороо, “Бөх Билэгт” дэвжээний бөх Мягмарын Бадарчид “Улсын заан” цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 113

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.7, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11.5, 11.7-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой бусад журам, заавар холбогдох тушаал, шийдвэрийг хууль, энэ журмын зохицуулалттай нийцүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Ч.УЛААН

Засгийн газрын 2020 оны
113 дугаар тогтоолын хавсралт

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ
ЗЭЭЛ ОЛГОХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ,
ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацийг дэмжих, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд Жижиг,



дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан (цаашид “Сан” гэх)-гаас хөнгөлөлттэй зээл (цаашид “зээл” гэх) олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх арилжааны банкныг сонгох, эргэн төлүүлэх, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Төсөл сонгон шалгаруулалтад Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6.1-д заасан байгууллагад бүртгүүлж, тодорхойлолт авсан аж ахуйн нэгж оролцох эрхтэй.

1.3.Санд зээлийн хүсэлт ирүүлсэн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (цаашид “ЖДҮҮЭ” гэх)-ийн төсөл (цаашид “төсөл” гэх)-ийг сонгон шалгаруулж, шийдвэр гаргах үүрэг бүхий “төсөл сонгон шалгаруулах хороо” (цаашид “хороо” гэх), аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж, шийдвэр гаргах үүрэг бүхий “төсөл сонгон шалгаруулах дэд хороо” (цаашид “дэд хороо” гэх) тус тус ажиллана. Хороо, дэд хороо үйл ажиллагаандаа энэ журмыг мөрдөнө.

1.4.ЖДҮҮЭ-д дараах тохиолдолд зээл олгохгүй:

1.4.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11.11-д заасан;

1.4.2.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 23.6-д заасан болон Сум хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;

1.4.3.Сангаас авсан зээлээ төлсөн боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

1.4.4.Монголбанкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;

1.4.5.төслийн нийт хөрөнгө оруулалтын тооцоололд өөрийн хөрөнгө оруулалт нь 30 хувьд хүрээгүй;

1.4.6.байгаль орчин ба хүний эрүүл мэндэд хортой технологи, материал хэрэглэсэн, экологийн хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;

1.4.7.тухайн төсөл болон төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрөөгүй;

1.4.8.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг

болон танилцуулдаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компанийн захирлын албан тушаал эрхэлж байгаа хүн, эсхүл түүний гэр бүлийн гишүүд хувь эзэмшдэг бол;

1.4.9.ЖДҮҮЭ-ээр бүртгүүлсэн боловч харилцан хамаарал бүхий этгээдүүдийн сүүлийн нэг жилийн нэгтгэн тооцсон борлуулалтын орлого нь 2,5 тэрбум төгрөг болон түүнээс дээш бол;

1.4.10.ЖДҮҮЭ нь нэг төслийг Сан болон аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагад давхардуулан ирүүлсэн;

1.4.11.ЖДҮҮЭ нь Сан болон аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагад нэгээс илүү төсөл ирүүлсэн.

Хоёр. Зээлийн эх үүсвэр, нөхцөл

2.1.Зээлийн эх үүсвэр нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

2.2.Зээлийн эх үүсвэрийг Төрийн сан дахь Сангийн дансанд төвлөрүүлнэ.

2.3.Төсвийн эх үүсвэрээс бүрдсэн зээлийг төгрөгөөр олгоно.

2.4.Хууль тогтоомж болон Засгийн газрын бодлого, төсөл хөтөлбөртэй уялдуулан, зээл олгох салбар, чиглэл, зээлийн хугацаа, хүү, эх үүсвэрийн багцын хуваарилалт зэргийг болон зээл олгоход шаардлагатай бусад нөхцөл, шаардлагыг (цаашид “Ерөнхий нөхцөл” гэх)-ийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.5.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.3, 16.4-т заасан эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгчийн зорилго, тухайн орон нутагт зориулан зарцуулах бөгөөд үүнтэй холбоотой харилцааг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын газрын гишүүн, Сангийн ажлын албаны захирал, тухайн орон нутгийн Засаг дарга эсхүл төсөл хэрэгжүүлэгч нарын хооронд байгуулах гурван талт гэрээгээр зохицуулна. Гэрээгээр зохицуулснаас бусад харилцааг энэ журмаар зохицуулна.

Гурав. Зээл олгох хэлбэр, хэмжээ

3.1.Зээлийг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11.7-д заасны дагуу Сангаас шууд болон арилжааны банкаар дамжуулан олгоно.



3.2.Сангаас шууд болон арилжааны банкаар дамжуулан олгох зээлийн доод хэмжээ 20,000,000 (хорин сая) төгрөг, дээд хэмжээ нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11.6-д заасны дагуу ЖДҮҮЭ-ийн сүүлийн жилийн борлуулалтын орлогоос хамааруулан дараах хязгаартай байна:

№	Ангилал	Зээл олгох хэлбэр	Борлуулалтын орлого (төгрөг)	Зээлийн дээд хэмжээ (төгрөг)
1.	Бичил	сангаас шууд олгох	0-100,0 сая хүртэл	100,0 сая хүртэл
			100,0-200,0 сая хүртэл	200,0 сая хүртэл
			200,0 саяас дээш	300,0 сая хүртэл
2.	Жижиг	банкаар дамжуулан олгох	300,0 саяас дээш	1,0 тэрбум хүртэл
3.	Дунд		1,0-2,5 тэрбум хүртэл	2,5 тэрбум хүртэл

3.3.Сангаас шууд зээл олгох тохиолдолд зээлдэгч нь зээлийн эрсдэлийн болон хөрөнгийн даатгалд жил бүр заавал даатгуулна.

Дөрөв. Дамжуулан зээл олгох банкиг сонгох, хяналт тавих

4.1.Дамжуулан зээл олгох банкиг сонгон шалгаруулах, хяналт тавих ажлын удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.2.Дамжуулан зээл олгох банк дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1.Монголбанкнаас тогтоосон арилжааны банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, заавал байлгах нөөцийн шаардлагыг сүүлийн 2 жилийн хугацаанд ханган ажиллаж байгаа, орон нутагт салбартай байх;

4.2.2.Сантай байгуулсан ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гэрээний үүргийг зөрчөөгүй байх;

4.2.3.олгосон зээлийн эрсдэлийг бүрэн хариуцаж, Сантай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах баталгааг тухайн банкны Монголбанкин дахь харилцах данснаас гаргасан байх;

4.2.4.энэ журмын дагуу олгох хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хэмжээ тухайн банкны жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай зээлийн хүүгийн доод түвшингээс бага байх;

4.2.5.сүүлийн 3 жилийн хугацаанд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар гадаадын зээл, тусламжийн болон төсвийн хөрөнгөөр дамжуулан олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зөрчилгүй байх;

4.2.6.сонгон шалгаруулалтын баримт бичигт шаардсан бусад шаардлагыг хангасан байх.

4.3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.9-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэмэлт нөхцөл, шаардлагыг тогтоосон бол энэхүү нэмэлт нөхцөл, шаардлагыг энэ журмын 4.1-д заасан ажиллах удирдамжид тусгана.

Тав. Зээлд хамрагдах төсөлд тавигдах шаардлага

5.1.Төсөл нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд эхлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт сайжруулалт, дуусгавар болох хугацааг тодорхой заасан байна.

5.2.Төсөл хэрэгжүүлэгчийн тухай мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

5.2.1.төслийн товч агуулга;

5.2.2.хуулийн этгээдийн нэр;

5.2.3.а.үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхэлж буй хаяг байршил;

б.хуулийн этгээдийн албан ёсны хаяг;

в.төсөл хэрэгжих байршил;

5.2.4.төслийн нийт хөрөнгө оруулалтын 30-аас доошгүй хувийг өөрийн эх үүсвэрээс бүрдүүлэхээр санхүүгийн тооцоололд тусгасан байх;

5.2.5.үйлдвэрлэл, үйлчилгээ болон худалдах бүтээгдэхүүний нэр, төрөл, танилцуулга;

5.2.6.одоогийн эрхэлж байгаа бизнесийн талаарх мэдээлэл.



5.3.Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагааны тухай мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

5.3.1.үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны технологийн ажиллагаа;

5.3.2.түүхий эдийн чанарын үзүүлэлт, нөөц;

5.3.3.үйлдвэрлэлийн хүчин чадал;

5.3.4.хэрэгжүүлэх төсөлд шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалт.

5.4.Удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

5.4.1.бүтэц, орон тоо;

5.4.2.ажиллагсдын мэргэжил, мэргэшил, ур чадвар;

5.4.3.шинээр бий болгох ажлын байрны тоо.

5.5.Зах зээлийн судалгаанд дараах мэдээллийг тусгана:

5.5.1.зах зээлийн судалгаа;

5.5.2.хэрэглэгчийн судалгаа;

5.5.3.гадаад, дотоод орчны (SWOT) шинжилгээ.

5.6.Эдийн засгийн тооцоонд дараах мэдээллийг тусгана:

5.6.1.үндсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний нийт орлого;

5.6.2.төслийн борлуулалтын орлогын тооцоо;

5.6.3.үйлдвэрлэлийн зардлын тооцоо;

5.6.4.бүтээгдэхүүний өртгийн тооцоо;

5.6.5.бүтээгдэхүүний борлуулалтын төлөвлөгөө;

5.6.6.үйлдвэр, үйлчилгээ, худалдааны үр ашгийн тооцоо;

5.6.7.төслийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалд хамрагдах тооцоо;

5.6.8.хөрөнгө оруулалтын тооцоо (өөрийн хөрөнгө оруулалтын хэмжээ, зээлийн зарцуулалтын тооцоо);

5.6.9.төслийн өгөөж, хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа.

5.7.Шинээр бизнес эхэлж байгаа тохиолдолд энэ журмын 5.2.6 дахь заалт хамаарахгүй.



5.8.Төслийн дүгнэлтэд энэ журмын 5.4-5.6-д заасан тооцоо судалгаанд үндэслэн төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн, эрсдэл зэргийг тооцоолсон мэдээллийг тусгана.

5.9.ЖДҮҮЭ нь төсөлд дараах материалуудыг хавсаргасан байна:

5.9.1.зээлийн өргөдөл (Сангаас баталсан загварын дагуу);

5.9.2.захирлын иргэний үнэмлэхийн хуулбар;

5.9.3.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шаардлагатай бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

5.9.4.хуулийн этгээдийн хаягийн тодорхойлолт, үүсгэн байгуулагчийн дэлгэрэнгүй лавлагаа;

5.9.5.барьцаалах үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн болон эзэмших эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газрын гэрээ, кадастрын зургийн хуулбар;

5.9.6.хэрэв зээлийн хэвийн үлдэгдэлтэй бол зээлийн гэрээ, зээлийн дансны баталгаажсан хуулга, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн хуулбар;

5.9.7.сүүлийн 2 жилийн санхүүгийн баталгаажсан тайлан (хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс);

5.9.8.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлсэн тухай тухайн жилийн тодорхойлолт;

5.9.9.нийгмийн даатгалд хамруулсан ажилтны тоо, төлж байгаа шимтгэлийн хэмжээ болон нийгмийн даатгалын байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт;

5.9.10.төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт;

5.9.11.төлсөн татварын хэмжээ болон татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх харьяа татварын албаны тодорхойлолт;

5.9.12.энэ журмын 5.2.4-т заасныг нотлох баримт;

5.9.13.тухайн төсөл болон төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрснийг илэрхийлсэн мэдэгдэл.



5.10.Төсөл, түүнд хавсаргасан материалын үнэн зөв байдлыг төсөл ирүүлэгч ЖДҮҮЭ бүрэн хариуцна.

Зургаа. Төсөл сонгон шалгаруулах хороо, дэд хорооны бүрэлдэхүүн

6.1.Хороо, дэд хороо нь дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдсэн найман хүний бүрэлдэхүүнтэй байна.

6.2.Дэд хорооны бүрэлдэхүүнд аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагын дарга болон хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл орох бөгөөд нарийн бичгийн даргаар аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн (цаашид “аймгийн мэргэжилтэн” гэх) байна.

6.3.Төлөөлөл оролцуулах төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр сүүлийн 3 жил үйл ажиллагаа явуулсан байна.

6.4.Хороо, дэд хорооны бүрэлдэхүүнд 4 төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөлөл оруулах бөгөөд төлөөлөл нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

6.4.1.эдийн засаг, санхүү, бизнес, инженер, эрх зүйн чиглэлээр магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй;

6.4.2.жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт ажиллаж байсан эсхүл тухайн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлын туршлагатай;

6.4.3.сүүлийн гурван жилд Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан албан тушаал хашиж байгаагүй;

6.4.4.Сантай бизнесийн холбоогүй;

6.4.5.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;

6.4.6.шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр бусдад төлөх төлбөргүй байх.

6.5. Хороо, дэд хороо хуралдааны зарчмаар шийдвэр гаргах ба хороо, дэд хорооны дарга, гишүүд нь хуралд тус бүр саналын нэг эрхтэй, нарийн бичгийн дарга саналын эрхгүй байна.

6.6.Хороо, дэд хорооны гишүүдийн дийлэнх олонх ирснээр хурал хүчинтэйд тооцогдох ба хурлын явцыг дуу хураагуур, дүрс бичлэгт хуулах болон цаасан хэлбэрээр тэмдэглэл хөтөлж, хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар шийдвэр гаргана.

6.7.Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

6.8.Хорооны бүрэлдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, дэд хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга тус тус батална.

6.9.Хороо, дэд хорооны шийдвэр нь тухайн төсвийн жилдээ хүчин төгөлдөр байна.

6.10.Хороо, дэд хороо нь өөрийн хуралдааны дэгийг батална.

6.11.Хороо, дэд хорооны үйл ажиллагаатай холбоотой зардлыг Сангаас санхүүжүүлж болно.

Долоо. Хороо, дэд хорооны эрх

7.1.Хороо нь Сангийн ажлын албаны судалсан төслийг хуралдаанаар хэлэлцэх, сонгон шалгаруулах, холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу шийдвэр гаргах эрхтэй.

7.2.Дэд хороо нь Сангийн ажлын алба болон аймгийн мэргэжилтний судалсан төслийг хуралдаанаар хэлэлцэх, сонгон шалгаруулах, холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу шийдвэр гаргах эрхтэй.

Найм. Хороо, дэд хорооны үүрэг

8.1.Хороо, дэд хорооны гишүүн нь дараах үүрэгтэй байна:

8.1.1.хороо, дэд хорооны гишүүн нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцох тухай бүрт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан мэдэгдлийг гаргах, Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл бүрт албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай хороо болон дэд хорооны даргад мэдэгдэх;

8.1.2.хороо, дэд хорооны гишүүд хурлын шийдвэр, зөвлөлдсөн асуудлын талаар бусдад задруулахгүй байх, үнэн зөв шалгаруулах, бусдад давуу байдал бий болгохгүй байх;



8.1.3.хороо, дэд хорооны гишүүн холбогдох хууль, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах;

8.1.4.хороо, дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга нь олонхын шийдвэрийг баталгаажуулан хурлын шийдвэрт гарын үсэг зурах;

8.1.5.хороо, дэд хороо нь гаргасан шийдвэрээ болон хорооны гишүүд өгсөн үнэлгээг бүрэн хариуцах.

Ес. Сангийн ажлын алба болон аймгийн мэргэжилтний үүрэг, хариуцлага

9.1.Сангийн ажлын алба болон аймгийн мэргэжилтэн дараах үүрэгтэй:

9.1.1.Төслийг судлах явцад олж авсан мэдээлэл, баримт бичиг, судалгааны явц, хурлын шийдвэрийн талаар бусдад задруулахгүй байх;

9.1.2.Сонгон шалгаруулалтад ирүүлсэн төслийг хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхолд үйлчлэх зорилгоор ашиглахгүй байх;

9.1.3.Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид журам зөрчиж, давуу байдал бий болгохгүй байх;

9.1.4.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомж, энэ журам болон эдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг мөрдлөг болгон ажиллах;

9.1.5.Ирүүлсэн төслийн мэдээллийг Сангийн зээлийн мэдээллийн санд (SMEF) тогтоосон хугацаанд үнэн зөв бүрэн оруулах.

9.2.Сангийн ажлын алба болон аймгийн мэргэжилтэн нь өөрийн судалсан төсөлд өгсөн үнэлгээг бүрэн хариуцна.

Арав. Төсөл сонгон шалгаруулалт зарлах, хүлээн авах

10.1.Төсөл хүлээн авах товыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

10.2.Сангийн ажлын алба улсын хэмжээнд төсөл хүлээн авах зарыг өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээнэ. Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага

нь энэхүү зарыг тухайн орон нутагт мэдээлэх үүргийг хүлээнэ. Төсөл хүлээн авах зард төсөл хүлээн авч эхлэх, дуусах хугацаа, байршил, цахим хаяг, зээлийн нөхцөл, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг тусгасан байна.

10.3.Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь тухайн орон нутагт хэрэгжих 20,000,000 (хорин сая) төгрөгөөс 300,000,000 (гурван зуун сая) хүртэл төгрөгийн санхүүжилт хүссэн, тухайн орон нутгийн бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна.

10.4.Сангийн ажлын алба нь 20,000,000 (хорин сая) төгрөгөөс 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөг хүртэл санхүүжилт хүссэн, энэ журмын 10.3-т заасан байгууллагад ирүүлснээс бусад бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна.

10.5.Сангийн ажлын алба болон аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авах хугацааг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, тухайн өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна.

10.6.Сангийн ажлын алба аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авах хугацаа зарлагдахаас бусад үед төсөл хүлээн авахгүй.

Арван нэг. Төсөл сонгон шалгаруулах үнэлгээний аргачлал, үе шат

11.1.Төслийн урьдчилсан болон нарийвчилсан үнэлгээг төслийн эрсдэлийн үнэлгээний олон улсын арга, аргачлалд суурилсан хийнэ.

11.2.Үнэлгээний арга, аргачлалыг жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн ажлын албаны захирал батална.

11.3.Сангаас шууд олгох зээлийн төсөл сонгон шалгаруулалтыг дараах 4 үе шаттайгаар үнэлнэ:

11.3.1.төслийн иж бүрдлийг Сангийн ажлын албаны ажлын хэсэг шалгах ба иж бүрдлийг бүрэн хангасан төслийг дараагийн шатанд шилжүүлэх;

11.3.2.төслийн урьдчилсан судалгааг Сангийн ажлын албаны мэргэжилтэн хийж, 100 хүртэл оноогоор дүгнэх ба 70-аас дээш оноо авсан төслийг дараагийн шатанд шилжүүлэх;



11.3.3.төсөлд нарийвчилсан судалгааг Сангийн ажлын албаны нарийвчилсан судалгааны ажлын хэсэг хийж, 100 хүртэл оноогоор дүгнэх ба 70-аас дээш оноо авсан төслийг дараагийн шатанд шилжүүлэх;

11.3.4.төслийг хороо, дэд хорооны хурлаар хэлэлцэж, гишүүн тус бүр 100 хүртэл оноогоор дүгнэн, дундаж оноог гаргах.

11.4.Хороо нь үе шат бүрт авсан онооны нийлбэрээр ихээс бага руу эрэмбэлэн жагсаалт гаргаж, зээлийн ерөнхий нөхцөлөөр зөвшөөрөгдсөн эх үүсвэрт багтаан тэргүүн ээлжинд санхүүжүүлэх төслүүдийн болон эх үүсвэр үлдсэн тохиолдолд санхүүжүүлэх төслүүдийн жагсаалтыг тус тус батална.

11.5.Аймгийн төсөл сонгон шалгаруулалтыг дараах үе шаттайгаар онооны системээр үнэлнэ:

11.5.1.төслийн иж бүрдлийг тухайн аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага шалгах ба иж бүрдлийг бүрэн хангасан төслийг дараагийн шатанд шилжүүлнэ;

11.5.2.төслийн урьдчилсан судалгааг тухайн аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага хийж, 100 хүртэл оноогоор дүгнэх ба 70-аас дээш оноо авсан төслийг дараагийн шатанд шилжүүлнэ;

11.5.3.төсөлд нарийвчилсан судалгааг Сангийн ажлын алба хийж, 100 хүртэл оноогоор дүгнэх ба 70-аас дээш оноо авсан төслийн жагсаалтыг аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагад шилжүүлнэ;

11.5.4.төслийг дэд хорооны хурлаар хэлэлцэж, гишүүн тус бүр 100 хүртэл оноогоор дүгнэн, дундаж оноог гаргана;

11.5.5.дэд хороо нь үе шат бүрт авсан онооны нийлбэрээр ихээс бага руу эрэмбэлэн жагсаалт гаргаж, зээлийн ерөнхий нөхцөлөөр зөвшөөрөгдсөн эх үүсвэрт багтаан тэргүүн ээлжинд санхүүжүүлэх төслүүдийн болон эх үүсвэр үлдсэн тохиолдолд санхүүжүүлэх төслүүдийн жагсаалтыг тус тус батална;

11.5.6.аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь энэхүү журмын 11.5.3-т заасан шаардлага хангасан төслийг дэд хороогоор яаралтай хэлэлцүүлэх арга хэмжээ авна;

11.5.7.дэд хорооны шийдвэрийг эрэмбэлсэн жагсаалтын хамт ажлын 5 хоногт багтаан тухайн аймгийн Засаг даргаар баталгаажуулж сангийн ажлын албанд хүргүүлнэ.



11.6.Сангаас банкаар дамжуулан олгох зээлийн төсөл сонгон шалгаруулалтыг дараах үе шаттайгаар, онооны системээр үнэлнэ:

11.6.1.төслийн иж бүрдлийг Сангийн ажлын албаны ажлын хэсэг шалгах ба иж бүрдлийг бүрэн хангасан төслийг дараагийн шатанд шилжүүлэх;

11.6.2.төслийн урьдчилсан судалгааг Сангийн ажлын албаны мэргэжилтэн хийж, 100 хүртэл оноогоор дүгнэх ба 70-аас дээш оноо авсан төслийг дараагийн шатанд шилжүүлэх;

11.6.3.төслийг хорооны хурлаар хэлэлцэж гишүүн тус бүр 50 хүртэл оноогоор дүгнэн дундаж оноог гаргах.

11.7.Хороо нь үе шат бүрт авсан онооны нийлбэрээр ихээс бага руу эрэмбэлэн жагсаалт гаргаж, зээлийн ерөнхий нөхцөлөөр зөвшөөрөгдсөн эх үүсвэрт багтаан тэргүүн ээлжинд санхүүжүүлэх төслийн болон эх үүсвэр үлдсэн тохиолдолд санхүүжүүлэх төслүүдийн жагсаалтыг тус тус батална.

11.8.Сангийн ажлын албанаас томилогдсон мэргэжилтэн тухайн төслийг зөвхөн нэг үе шатанд үнэлнэ. Тухайн төслийг өөр үе шатанд дахин үнэлэхийг хориглоно.

Арван хоёр. Гэрээ байгуулах, санхүүжилт олгох

12.1.Сангаас шууд олгох зээлийг дараах байдлаар санхүүжүүлнэ:

12.1.1.хороо болон тухайн аймгийн Засаг дарга нь шийдвэрээ гарсан даруйд битүүмжлэн Сангийн ажлын албанд хүргүүлнэ;

12.1.2.Сангийн ажлын алба хорооны шийдвэрийг хүлээн авч нэн даруй Сангийн ажлын албаны захирлын тушаалаар баталгаажуулна;

12.1.3.Сан энэ журмын 11.4, 11.5.7-т заасан хороо, аймгийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн аж ахуйн нэгжтэй Зээлийн болон барьцааны гэрээг байгуулж, санхүүжилтийг олгоно;

12.1.4.Сан нь гарааны бизнесийг дэмжих болон бичил бизнес эрхлэгчдэд итгэл үзүүлэх зорилгоор 20 сая төгрөгийн санхүүжилт хүссэн төслийн зээлд барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд барьцаа хөрөнгийн шаардлагыг 30 хүртэл хувиар бууруулан гэрээ байгуулж, санхүүжилтийг олгож болно;

12.1.5.зээлийн санхүүжилтийг төслийн хэрэгжилттэй уялдуулан зээлдэгчийн худалдан авалт, төслийн гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож болно.



12.2.Банкаар дамжуулан олгох зээлийг дараах байдлаар санхүүжүүлнэ:

12.2.1.хороо нь шийдвэрээ гарсан даруйд битүүмжлэн Сангийн ажлын албанд хүргүүлнэ;

12.2.2.Сан нь энэ журмын 11.7-т заасан хорооны шийдвэрийг хүлээн авч Сангийн ажлын албаны захирлын тушаалаар баталгаажуулж, тухайн ЖДҮҮЭ-ийн сонгосон банкинд хүргүүлнэ;

12.2.3.банк жагсаалтаар хүргүүлсэн төслийн зээлийн судалгааны материалыг 14 хоногийн дотор төсөл хэрэгжүүлэгчээс бүрэн хүлээн авч, түүнээс хойш хуанлийн 30 хоногт багтаан судалж, шаардлага хангасан төслийн жагсаалт банкны зээлийн хорооны шийдвэр, зээлийн гэрээ, барьцааны гэрээ болон нэхэмжлэлийн хамт баталгаажуулан Сангийн ажлын албанд хүргүүлнэ;

12.2.4.банк барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг зээлийн хорооны шийдвэрийн хамт Зээлийн батлан даалтын санд хүргүүлэх ба зээлийн батлан даалтын сан 14 хоногт багтаан батлан даалт гаргах эсэх асуудлаар шийдвэр гаргана. Банк зээлийн батлан даалтын сангийн шийдвэрийг гарсан даруйд баталгаажуулан Сангийн ажлын албанд хүргүүлнэ;

12.2.5.Сан нь энэ журмын 12.2.3, 12.2.4-т заасан хугацаанд банкнаас ирүүлсэн шийдвэрийг үндэслэн банкинд санхүүжилтийг шилжүүлнэ;

12.2.6.банк нь Сангаас санхүүжилт шилжүүлснээс хойш ажлын 3 өдөрт багтаан төсөл хэрэгжүүлэгчид зээлийг олгоно;

12.2.7.банк нь энэ журмын 12.2.3, 12.2.4-т заасан хугацаанд холбогдох шийдвэрийг баталгаажуулж ирүүлээгүй тохиолдолд холбогдох шийдвэрийг хүчингүй болсонд тооцно. Үүнээс үүдэн гарах хохирлыг холбогдох этгээд хариуцна;

12.2.8.ЖДҮҮЭ нь 2 хүртэл банкаар төслийн зээлийн судалгааны материалыг судлуулж болох бөгөөд энэ журмын 12.2.3, 12.2.4-т заасан хугацааг нэгэн адил дагаж мөрдөнө.

Арван гурав. Ил тод байдал

13.1.Төсөл сонгон шалгаруулалтын үе шат бүрт шалгараагүй төслүүдийн баримт бичгийг үндэслэл, тайлбарын хамт төсөл ирүүлэгчид буцаана.

13.2.Хороо, дэд хороо нь төсөл сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг цахимаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулна.

13.3.Сан, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төслийн судалгааны явцыг тухай бүр цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлнэ.

13.4.Хороо болон дэд хорооны хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан шалгарсан аж ахуйн нэгжийн мэдээллийг Сан болон аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь цахим хуудсаараа дамжуулан мэдээлнэ. Төсөл ирүүлэгчийн хүсэлтийн дагуу албан бичгээр хариуг өгнө.

13.5.Зээл авсан иргэний овог нэр, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ.

Арван дөрөв. Зээлдэгчийн мэдээллийн сан

14.1.Сангийн ажлын алба зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн холбогдох мэдээллийг агуулсан Зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлнө.

14.2.Сангийн ажлын алба зээлийн ангиллыг тогтоохдоо Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд нарын хамтарсан тушаалаар баталсан Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг баримтална.

14.3.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд тогтмол нийлүүлнэ.

Арван тав. Зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагаа

15.1.Сангийн ажлын алба зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлнэ.

15.2.Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд Сангийн ажлын алба нь чанаргүй активын ангилалд оруулж, Монголбанкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ.



15.3.Дамжуулан олгосон банк гэрээний үүргээ биелүүлээгүй, эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг Сангийн ажлын алба хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг Сан, банктай байгуулах гэрээгээр нарийвчлан зохицуулна.

Арван зургаа. Зээлийн зарцуулалтад хяналт тавих

16.1.Сангийн ажлын алба нь сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавихдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

16.1.1.зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн төслийн үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн талаарх тайланг зээлдэгчээс улирал бүр гаргуулан авах;

16.1.2.Сангийн үйл ажиллагаа, орлого, зарлагын гүйцэтгэлд жил бүр хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэх.

16.2.Сангийн ажлын алба жилд нэгээс доошгүй удаа зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд иж бүрэн эсхүл түүвэрчилэн хяналт, шалгалт хийнэ. Хяналт, шалгалтын дүнг тухай бүр нэгтгэн жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

16.3.Дамжуулан зээл олгож буй арилжааны банкны гэрээний биелэлтэд Сангийн ажлын алба болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан ажлын хэсэг хяналт тавина.

16.4.Банкаар дамжуулан олгосон зээлийг зориулалт бусаар ашигласан, хууль, журам зөрчиж олгосон нь хяналт, шалгалтаар тогтоогдсон тохиолдолд зээл авсан өдрөөс эхлэн уг зээлийг дамжуулан олгосон банкны арилжааны зээл рүү шилжүүлэх арга хэмжээ авч, тухайн зээлийн эх үүсвэрийг банкны эх үүсвэрээс бүрэн дүнгээр нь Санд буцаан төвлөрүүлнэ. Энэ зохицуулалтыг Сан, банктай хамтран ажиллах гэрээгээр нарийвчлан зохицуулна.

16.5.Сангаас шууд олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь Сангийн хяналт, шалгалтаар тогтоогдсон бол зээлдэгчийн эх үүсвэрийг буцаан татаж, холбогдох байгууллагад шилжүүлнэ. Энэ зохицуулалтыг Сан, зээлдэгчтэй байгуулах гэрээгээр нарийвчлан зохицуулна.

16.6.Сангаас зээл авсан этгээд зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь тогтоогдсон, зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Сангаас дахин зээл олгохгүй.

16.7.Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй буюу энэ журамд заасныг зөрчиж төсөл сонгон шалгаруулсан, төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт, шалгалтаар тогтоогдсон бол холбогдох албан тушаалтанд зохих хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Арван долоо. Мэдээ тайлан гаргах, хүлээн авах

17.1.Банк, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага олгосон зээлийн тайлан, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь ирүүлсэн төслийн талаарх мэдээллийг тухай бүр нэгтгэн санд хүргүүлнэ.

17.2.Сангийн ажлын алба улсын хэмжээнд ирүүлсэн төсөл, олгосон зээлийн мэдээллийг нэгтгэн дараа сарын 10-ны дотор жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад болон шаардлагатай тохиолдолд холбогдох газарт тухай бүрт тус тус хүргүүлнэ.

17.3.Энэ журмын 6.9-д заасан хугацаа дуусмагц Сангийн ажлын алба, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь ажлын 5 хоногт багтаан аж ахуйн нэгжид мэдэгдэл хүргүүлнэ.

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

“ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, УУР АМЬСГАЛЫН НОГООН САН ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”

Уур амьсгалын ногоон сан (“Сан”) болон Монгол Улсын Засгийн газар (“Засгийн газар”) нь Уур амьсгалын ногоон сангийн Үндсэн баримт бичгийн 7 ба 8 дугаар хэсгийн дагуу Сан болон Санд хамааралтай хүмүүсийн эрх ямба, дархан эрхийг Монгол Улсад хангаж, баталгаажуулах шаардлага байгааг ухамсарлаж;

Сан болон түүнд хамаарал бүхий хүмүүст эрх ямба, дархан эрхийг олгох нь Сангийн чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэдгийг Сан болон Засгийн газар хүлээн зөвшөөрч;

энэ асуудлаар хэлэлцээр байгуулахыг эрмэлзэн;



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН УУР АМЬСГАЛЫН
НОГООН САН ДАРААХ ЗҮЙЛИЙГ ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ:**

**1 дүгээр зүйл
Нэр томъёоны тайлбар**

Энэхүү хэлэлцээрийн зорилгын хүрээнд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (a) “Хяналтын нэгж” гэж Үндсэн баримт бичгийн дагуу Удирдах зөвлөлөөс байгуулсан үнэлгээний нэгж, ёс зүйн нэгж болон гомдол шийдвэрлэх механизмыг;
- (b) “Хэлэлцээр” гэж Хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар болон Сан хоорондын энэхүү хэлэлцээрийг;
- (c) “Сангийн архив” гэж Санд хамаарах, эсхүл Сангаас боловсруулан гаргасан машинаар уншигдахуйц, эсхүл бусад хэлбэрээр боловсруулагдсан эсэхээс үл хамаарах хэлбэр бүхий бүх бүртгэл, шуудан харилцаа, бичиг баримт, гар бичмэл, кино зургийн болон гэрэл зургийн кадр, кино, дуу бичлэг, компьютер дахь дата мэдээлэл эсхүл хэвлэлийн мэдээний дата, бусад тоон хэлбэрт оруулсан мөн электрон бүртгэл, эсхүл нэгтгэсэн дата болон өөр бусад бүх материалыг хэлнэ;
- (d) “Удирдах зөвлөл” гэж Сангийн Удирдах зөвлөлийг хэлнэ;
- (e) “Гаалийн татвар” гэж Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал болон сэлбэг зэрэг албаны зориулалтаар Сангийн шугамаар импортлосон эсхүл экспортлосон эд зүйлст гаалийн тарифын дагуу ногдуулах татвар, хураамж төлбөрийг;
- (f) “Хураамж” гэж албаны зориулалтаар худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд ногдуулсан онцгой албан татвар болон аливаа бусад төлбөрийг;
- (g) “Гүйцэтгэх захирал” гэж Удирдах зөвлөлөөс томилсон Нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүнийг;
- (h) “Сангийн даалгавраар үүрэг гүйцэтгэж байгаа шинжээч” гэж Сантай байгуулсан хэлэлцээр (шинжээч ба Сан хооронд, аль эсхүл байгууллага ба Сан хооронд)-ийн хүрээнд үйлчилгээ үзүүлж буй үүнд Хариуцлагын нэгжүүд, Удирдах зөвлөлийн комиссын гишүүд, мэргэжлийн баг болон ажлын хэсгүүд болох зөвлөх эсхүл шинжээчийг;
- (i) “Засгийн газар” гэж Монгол Улсын Засгийн газрыг хэлнэ;
- (j) “Ажиглагч” гэж Удирдах зөвлөлийн хуралд оролцохоор уригдсан жинхэнэ ажиглагч болон Сангаас бүрэн эрх олгосон Ажиглагчийн томилсон төлөөлөгчийг;

- (k) “Албан тушаалтан” гэж орон нутагт ажиллаж буй эсхүл цагаар ажиллаж буй ажилтнуудаас бусад аль улсын иргэний харьяалалтай эсэхийг үл харгалзан Удирдах зөвлөлийн гишүүд, орлогч гишүүд, тэдгээрийн зөвлөхүүд, Гүйцэтгэх захирал, Нарийн бичгийн дарга нарын газрын ажилтан болоод Хариуцлагын нэгжүүдийн ажилтан зэрэг Сангийн аливаа бусад албан хаагч болон ажилтныг;
- (l) “Тал” эсхүл “Талууд” гэж тухайн тохиолдол бүрт хэрэглэгдэж байгаа утгаар нь Сан болон/эсхүл Монгол Улсын Засгийн газрыг;
- (m) “Сангийн өмч” гэж эд хөрөнгө, хуримтлал, орлого болон Санд хамаарах эсхүл Сангийн эзэмшиж буй, хэрэгжүүлж буй эрхүүдийг;
- (n) “Нарийн бичгийн дарга нарын газар” гэж Үндсэн баримт бичгийн дагуу байгуулагдсан Сангийн Нарийн бичгийн дарга нарын газрыг;
- (o) “Албан татвар” гэж нэмүү өртгийн албан татвар болон /эсхүл түүнтэй адил төстэй бусад татваруудыг хамруулсан аливаа шууд ба шууд бус татварыг.

2 дугаар зүйл **Зорилго**

Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрийн зорилго, чиг үүргийг үр дүнтэйгээр гүйцэтгэхэд шаардлагатай статус, эрх ямба, хөнгөлөлт болон дархан эрхийг Санд олгоход оршино.

3 дугаар зүйл **Эрх зүйн байдал**

Сан нь хуулийн этгээдийн хэлбэртэй байх ба дараах асуудлаар эрх зүйн бүрэн чадамжтай байна:

- (a) Гэрээ хийх;
- (b) Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө эзэмших, захиран зарцуулах;
- (c) Эрх зүйн процесс ажиллагааг эхлүүлэх.

4 дүгээр зүйл **Шүүн таслах ажиллагаанаас чөлөөлөгдөх дархан эрх**

1. Сан бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж буй мөнгө зээлдүүлэх, аливаа баталгаа гаргах, үнэт цаас худалдан авах, худалдах эсхүл үнэт цаасны баталгаа гаргахтай холбогдуулан, Сангийн төв болон салбар байрлаж байгаа, эсхүл мэдэгдэл хүлээн авах эрх бүхий төлөөлөгч томилогдсон улсын шүүхийн харьяаллын дагуух шүүхэд Сангийн эсрэг үүсгэсэн хэргээс бусад бүх төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас чөлөөлөгдөх дархан эрхийг эдэлнэ.



2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийг үл харгалзан Засгийн газар нь Монгол Улсыг ямар нэг байдлаар төлөөлж буй төлөөлөгчөөр дамжуулж, эсхүл Сантай шууд болон шууд бусаар харилцаж буй аливаа аж ахуйн нэгж, хувь этгээдийн зүгээс, төлөөлөгчөөр дамжуулан Сангийн эсрэг аливаа нэхэмжлэл гаргахгүй.

3. Сангийн эсрэг шүүхийн эцсийн дүгнэлт гарахаас өмнө, Сангийн өмч болон эд хөрөнгө хаана байрлаж, хэн эзэмшиж байгаагаас үл хамааран, тэрхүү өмч, эд хөрөнгө аливаа хэлбэрийн албадан хураах, битүүмжлэх болон шийдвэр гүйцэтгэлээс чөлөөлөгдөнө.

5 дугаар зүйл **Эд хөрөнгийн халдашгүй байдал**

Сангийн өмч, эд хөрөнгө хаана байрлаж, хэн эзэмшиж байгаагаас үл хамааран, үзлэг нэгжлэг хийх, шалгах, албадан барьцаалах, хураах шүүхийн гүйцэтгэх ажлын болон хуулийн хүрээнд хэрэгжүүлж буй бусад хэлбэрийн аливаа үйлдлээс хамгаалагдах дархан эрхтэй байна.

6 дугаар зүйл **Архивын халдашгүй байдал**

Сангийн архив болон түүний эзэмшил, ашиглалтад байгаа цахим болон бусад аливаа хэлбэрээр хадгалагдаж буй мэдээлэл болон бичиг баримт, хаана ч байрлаж байсан халдашгүй байна.

7 дугаар зүйл **Эд хөрөнгө хязгаарлалтаас ангид байх**

1. Сангийн зорилго, чиг үүргийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх хүрээнд мөн энэхүү хэлэлцээрт болон Монгол Улсын хууль тогтоомжид заасан шаардлагуудын хүрээнд Сангийн бүх өмч болоод эд хөрөнгө нь хязгаарлалт, зохицуулалт, хяналт болон аливаа хориг тавих арга хэмжээнээс ангид байна.

2. Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд Санг санхүүгийн хяналт, зохицуулалт, эсхүл аливаа нэг хориг арга хэмжээгээр хязгаарлахгүй:

- (a) Мөнгөн хөрөнгийн сан, алт болон бүх төрлийн валют эзэмших мөн бусад улсын валютын дансаар тооцоо хийж болно;
- (b) Мөнгөн хөрөнгийн сан, алт болон валютыг тухайн улс дотор, эсхүл нэг улсаас нөгөө улс руу чөлөөтэй шилжүүлэх, мөн өөрийн эзэмшилд буй валютыг өөр улсын валютаар солих эрхтэй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрхийг хэрэгжүүлэхэд Сан нь Засгийн газрын аливаа төлөөлөлтэй Сангийн ашиг сонирхолд хохирол учруулахааргүй, үр ашигтай байхыг үндэс болгон харилцан ажиллана.

8 дугаар зүйл **Харилцаа холбоонд хамаарах эрх ямба**

Сангийн албаны харилцаа холбооны хувьд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудад олгож буй албаны харилцаа холбооны нөхцөлөөс дутуугүй тааламжтай нөхцөлийг олгоно.

9 дүгээр зүйл **Сангийн албан тушаалтнуудын эрх ямба, дархан эрх**

1. Удирдах зөвлөлийн гишүүд, орлогч гишүүд, тэдгээрийн зөвлөхүүд, Гүйцэтгэх захирал, Сангийн албан хаагч, ажилтнууд болон Сангийн даалгавраар үүрэг гүйцэтгэж байгаа шинжээчид нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

- (a) Сангийн зүгээс дархан эрхээсээ татгалзсанаас бусад бүх нөхцөлд, албан үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйлдэлд нь хамааруулан үүсгэсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ангид байх;
- (b) Тухайн орон нутгийн иргэн эсхүл харьяат биш бол цагаачлахад тавигдах шаардлага, гадаадын иргэдийн бүртгэлд тавигдах шаардлага, үндэсний үйлчилгээний үүрэг, болон солилцооны журмын дагуу авах үйлчилгээ нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бусад буюу харьцуулж болохуйц түвшний гадаадын байгууллагын суурин төлөөлөгч, албан хаагч ба харгалзах зиндааны ажилтнуудад олгогддог үйлчилгээ авах;
- (c) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй харьцуулж болохуйц түвшний бусад олон улсын байгууллагын төлөөлөгч, албан тушаалтан, ажилтанд үзүүлдэг аяллын үйлчилгээ авах.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна, Удирдах зөвлөлийн гишүүд, орлогч гишүүд, Гүйцэтгэх захирал ажил үүргээ биелүүлэн Монгол Улс руу орох болон тус улсаас гарч явах хугацаанд баривчлах эсхүл саатуулагдахаас ангид байж, хувийн ачаа тээшээ хураалгахаас хамгаалагдах дархан эрхийг эдэлнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт хамаарахгүй Сангийн зүгээс хурал, зөвлөгөөнд оролцохоор уригдсан ажиглагчид болон хувь хүмүүс нь Сангийн зүгээс удирдагсдын эрх зүйн чадамжийн хүрээнд албан үүргээ гүйцэтгэх үедээ хэлсэн буюу бичсэн үгс, хийж гүйцэтгэсэн үйлдлийнхээ төлөө бүх төрлийн эрх зүйн процесс ажиллагаанаас ангид байх дархан эрхийг эдэлнэ.



10 дугаар зүйл **Зорчих баримт бичгийг хүлээн зөвшөөрөх** **болон зорчих нөхцөлийг хөнгөвчлөх**

1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бөгөөд шаардлагатай нөхцөлд Монгол Улс Сангийн Удирдах зөвлөлийн гишүүд, орлогч гишүүд, тэдгээрийн зөвлөхүүд, Гүйцэтгэх захирал, Сангийн албан хаагчид, ажилтнууд мөн Сангийн даалгавраар үүрэг гүйцэтгэж байгаа шинжээч даалгавраар үүрэг гүйцэтгэж байгаа шинжээчийн виз мэдүүлэх ажиллагааг хурдасгах замаар шилжих хөдөлгөөнийг хялбарчилна.

2. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бөгөөд шаардлагатай нөхцөлд Сангаас зохион байгуулж буй хурал, уулзалтад оролцох ажиглагчид болон Сангийн шугамаар уригдсан бусад хүмүүсийн виз мэдүүлэх нөхцөлийг хөнгөвчлөх арга хэмжээг Монгол Улс авна.

3. Засгийн газар нь Удирдах зөвлөлийн гишүүд, орлогч гишүүд, тэдгээрийн зөвлөхүүд, Гүйцэтгэх захирал, Сангийн албан хаагч, ажилтнууд болон Сангийн даалгавраар үүрэг гүйцэтгэж байгаа шинжээчийг НҮБ-ын зорчих баримт бичиг (laissez-passer), хэрэв НҮБ зөвшөөрсөн бол, эсхүл Удирдах зөвлөлөөс баталсан бусад зорчих баримт бичиг ашиглахыг хүлээн зөвшөөрнө.

11 дүгээр зүйл **Албан татвараас чөлөөлөх**

1. Сан, түүний эд хөрөнгө, өмч, орлого, үйл ажиллагаа мөн гүйлгээ бүх төрлийн гаалийн болон албан татвараас чөлөөлөгдөнө. Сан нь аливаа орлогоос авах хураамж, албан татвар төлөх үүргээс чөлөөлөгдөнө.

2. Сангаас Удирдах зөвлөлийн гишүүд, орлогч гишүүд, тэдгээрийн зөвлөхүүд, Гүйцэтгэх захирал, Сангийн албан хаагч, ажилтнууд болон Сангийн даалгавраар үүрэг гүйцэтгэж байгаа шинжээчид олгож буй цалин, мөн урамшуулалд татвар ногдуулахгүй. Сангаас цалинждаг Монгол Улсад оршин суудаг Монгол Улсын иргэний олгож буй цалин урамшуулалд татвар ногдуулах эрхийг Засгийн газар эдэлнэ.

3. Засгийн газар хэний эзэмшилд байгаагаас үл хамааран Сангаас гаргасан аливаа облигаци, үнэт цаас, тэдгээрээс авах ноогдол ашиг, эсхүл хүүнд, татвар ногдуулахгүй:

- (a) Зөвхөн Сангаас гаргасан гэх шалтгаанаар тухайн облигаци эсхүл үнэт цаасыг тухайлан ялгаж авч үзэж байгаа тохиолдолд; эсхүл;
- (b) Тухайн татвар ногдуулах улсын харьяалал нь уг облигаци, үнэт цаасыг гаргасан газар, төлбөр нэхэмжилсэн болон төлсөн валютыг

гаргасан улс, эсхүл Сангийн гол үйл ажиллагаа явуулдаг газар эсхүл үйл ажиллагаа явуулдаг албан газар байрладаг улс байх тохиолдол тус тус хамаарна.

4. Засгийн газар нь Сангаас гаргасан аливаа облигаци, үнэт цаас, тэдгээрээс авах ноогдол ашиг эсхүл хүүнд хэний эзэмшилд байгаагаас үл хамааран татвар ногдуулахгүй:

- (a) Тухайн облигаци эсхүл үнэт цаасыг зөвхөн Сангаас баталгаа өгсөн гэх шалтгаанаар тухайлан ялгаж авч үзэж байгаа тохиолдолд; эсхүл
- (b) Тухайн татвар ногдуулах улсын харьяалал нь Сангийн гол үйл ажиллагаа явуулдаг албан газар байрладаг эсхүл үйл ажиллагаа явуулдаг албан газар байрладаг улс байх тохиолдол тус тус хамаарна.

12 дугаар зүйл **Эрх ямба, дархан эрхээс татгалзах**

Сан нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд Удирдах зөвлөлийн гишүүд, орлогч гишүүд, тэдгээрийн зөвлөхүүд, Гүйцэтгэх захирал, Сангийн албан хаагч, ажилтнууд, Сангийн даалгавраар үүрэг гүйцэтгэж байгаа шинжээчдэд олгосон эрх ямба, дархан эрх болон хөнгөлөлтүүдийг харгалзан үзэж, тэдний хувийн ашиг сонирхлын тулд бус харин Сангийн чиг үүрэгт нийцүүлэн, Сангийн ашиг сонирхолд нийцэж буй хэмээн тодорхойлсон тохиолдолд мөн ийнхүү тодорхойлсон аргаар энэхүү Хэлэлцээрийн дагуу олгогдсон эрх ямба, дархан эрх, хөнгөлөлтөөс татгалзаж болно. Сан нь эрх ямба, дархан эрхээсээ татгалзах эрхтэйн зэрэгцээ тухайн тохиолдлоос хамааран, Сангийн саналаар дархан эрх эдлэх нь шударга ёсыг сахиулахад харшилж буй, мөн түдгэлзүүлсэн тохиолдолд тэрхүү дархан эрх олгосон зорилго болон Сангийн ашиг сонирхолд хохирол учруулахгүйгээр Сан Удирдах зөвлөлийн гишүүд, орлогч гишүүд, тэдгээрийн зөвлөхүүд, Гүйцэтгэх захирал, Сангийн албан хаагч, ажилтнууд, Сангийн даалгавраар үүрэг гүйцэтгэж байгаа шинжээчийн дархан эрхийг түдгэлзүүлэх үүрэг хүлээнэ.

13 дугаар зүйл **Маргаан шийдвэрлэх**

Энэхүү хэлэлцээртэй холбогдон гарах аливаа маргаан, ойлголтын зөрүү, эсхүл нэхэмжлэл, түүнчлэн хэлэлцээрийг хүчингүйд тооцох, цуцлах, зөрчих, хэрэглэх, тайлбарлах, эсхүл хүчин төгөлдөр болгох асуудлыг Арбитрын Байнгын Шүүхийн 2012 оны журмын дагуу Арбитрын шүүхээр шийдвэрлэнэ:



- (a) Арбитрчийн тоо гурав байна;
- (b) Арбитрын ажиллагааны харьяалал нь Арбитрын Байнгын Шүүх (PCA) байрлаж буй Нидерланд улсын Гааг хот (The Hague) байна;
- (c) Арбитрын ажиллагаа явуулах хэл англи хэл байна; мөн
- (d) Талууд, арбитрын үндсэн шийдвэрийн талаар шүүхэд эсхүл эрх бүхий бусад байгууллагад гомдол гаргах эрхээсээ холбогдох хууль, тогтоомжийн дагуу түдгэлзсэн байна.

14 дүгээр зүйл Бусад зүйл

1.Энэхүү хэлэлцээрийн хүрээнд шаардлагатай тохиолдолд Засгийн газар болон Сангийн хооронд нэмэлт хэлэлцээрүүдийг байгуулж болно.

2.Энэхүү хэлэлцээрийг монгол, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй. Монгол, англи хэлээрх эх бичвэрүүдийн хооронд зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

3.Уур амьсгалын ногоон сангийн Гүйцэтгэх захиралд хэлэлцээр хүчин төгөлдөр болох тухай бүх шаардлагыг хангасан тухайгаа Гадаад харилцааны яам мэдэгдсэн өдрөөс эхлэн тус хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

Хэмээснийг нотлон бүрэн эрх олгосны дагуу тус тусын төлөөлөгчид энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

НАМСРАЙН ЦЭРЭНБАТ

**БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**УУР АМЬСГАЛЫН НОГООН
САНГ ТӨЛӨӨЛЖ**

YANNICK GLEMAREC

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Огноо: 20/11/2019

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeleel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.5

Индекс: 200003